

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2006 оны 8 дугаар сарын
21-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх
зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох
журмын тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.5, “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3-д заасныг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох журам”-ын хавсралтаар тусгай зөвшөөрөл эзэмшигч Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын зохицуулалтын үйлчилгээний төрөл, хөлсний хэмжээг хавсралт 1-д, Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогч байгууллагын зохицуулалтын үйлчилгээний төрөл, хөлсний хэмжээг хавсралт 2А,Б-д, ~~Үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагын зохицуулалтын үйлчилгээний төрөл, хөлсний хэмжээг хавсралт 3-т,~~ /Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 02 дугаар сарын 02-ны №21 тоот тогтоолоор хүчингүй/ Хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хавсралт 4-д, Валют солих цэгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хавсралт 5-д тус тус заасны дагуу тогтоосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Үнэт цаасны хорооны даргын 2003 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 30 тоот тушаалын 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 09 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү журам гарсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 2006 онд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2006 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор Хадгаламж банкин дахь Санхүүгийн зохицуулах хорооны 1700041422 тоот дансанд төвлөрүүлсүгэй.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчлан ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧЭЭС
ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХӨЛС ТОГТООХ ЖУРАМ

1.1 Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгогдсон санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагуудаас зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ны дансанд төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Хороо нь “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”- ийн 6.1.5, “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3-д заасныг үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоохдоо санхүүгийн тогтвортой байдлыг хангах, Хорооноос үзүүлж буй зохицуулалтын үйлчилгээний төрөл, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахыг эрхэмлэнэ.

~~1.3 Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон хувьцаат компани, даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогч байгууллага, хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо, валют солих цэгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, иргэд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараа оны 3 дугаар сарын сарын 1-ний дотор Хадгаламж банкин дахь Хорооны 1700041422 тоот дансанд төвлөрүүлнэ.~~

~~1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын зохицуулалтын үйлчилгээний төрөл, хөлөний хэмжээг хавсралт 1-д, Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогч байгууллагын зохицуулалтын үйлчилгээний төрөл, хөлөний хэмжээг хавсралт 2А,Б-д, Үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагын зохицуулалтын үйлчилгээний төрөл, хөлөний хэмжээг хавсралт 3-г, Хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлөний хэмжээг хавсралт 4-д, Валют солих цэгийн зохицуулалтын үйлчилгээний хөлөний хэмжээг хавсралт 5-д тус тус заасны дагуу тооцон Хорооны дээр дурдсан дансанд байршуулна.~~

1.3. Энэхүү журмын хавсралт ёсоор батлагдсан хөлсийг холбогдох мэргэжлийн байгууллага, иргэдээс дор дурдсан хуваарийн дагуу төвлөрүүлнэ:

1.3.1. Жил бүр төвлөрүүлэх хөлсийг дараа оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Хадгаламж банкин дахь тус Хорооны 1700041422 тоот дансанд;

1.3.2. Нэгж арилжаа, гүйлгээ тутмаас тухай бүр суутгах замаар төвлөрүүлэх хөлсийг тухай бүр үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага дахь Хорооны дансанд; /Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор хүчингүй/

1.3.3. Үйлчилгээ үзүүлсэн тухай бүр нэг удаа авах үйлчилгээний хөлсийг тухай бүр Хадгаламж банкин дахь тус Хорооны 1700041422 тоот дансанд.

1.4. Тус Хорооны зохицуулалт үйлчилгээнд хамрагдаж буй эрх бүхий мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн болон иргэд энэхүү журмын зохих хавсралтуудад заасан хөлсөө тогтоосон хэмжээгээр энэ журмын 1.3-т заасан хугацаанд холбогдох дансанд бүрэн байршуулна.

/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 02 дугаар сарын 02-ны №21 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

1.5 Хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчээс зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд төвлөрүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутам 0.5 хувийн алданги тооцон авна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

*~~Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 33 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт
/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 02 дугаар сарын 02-ны №21 тоот тогтоолоор хүчингүй/~~*

*~~Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралт
/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 02 дугаар сарын 27-ны №29 тоот тогтоолоор хүчингүй/~~*

/2007 оны 02 дугаар сарын 27-ны өдөр хүртэлх нэмэлт, өөрчлөлтийг тусгав./